

Энэхүү гэрээг нэг талаас 2822296 регистрийн дугаартай, Монгол Улсын хуулийн этгээд болох "ДИЖИКОМ"ХХК (цаашид "Үйлчлэгч" гэнэ), нөгөө талаас "....." регистрийн дугаартай, "....." (цаашид "Хэрэглэгч" гэнэ), (цаашид хамтад нь талууд гэх) нар нь дараах нөхцлүүдийг харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

1. Ерөнхий зүйл

- 1.1 Үйлчлэгч нь хэрэглэгчийн сонгосон мэдээлэл дамжуулах (интернэт, voice) үйлчилгээг үзүүлнэ.
- 1.2 Үйлчлэгч нь хэрэглэгчийн сонгосон интернэтийн хурдаар үйлчилгээ үзүүлнэ.
- 1.3 Гэрээ 24 сарын хугацаатай болно.
- 1.4 Гэрээний хугацаа дуусгавар болоход аль нэг тал гэрээг цуцлах тухай санал тавиагүй бол уг гэрээг анх байгуулсан хугацаа болон нөхцөлөөр дахин сунгагдсанд тооцно.
- 1.5 Үйлчилгээний төрөл, түүнд тохирсон үнэ болон эрх нээх хугацааг хэрэглэгч тус бүр дээр хавсралтаар баталж, энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно.
- 1.6 Гэрээнд мэдээлэл дамжуулах үйлчилгээний үнэ, хэрэглэгчийн мэдээллийг тус тус хавсаргав.
- 1.7 Үйлчилгээ авахаар захиалга өгсөн өдрөөс хойш ажлын 3-5 хоногт багтаан үйлчилгээ үзүүлнэ.

2. Үйлчилгээ

- 2.1 Үйлчлэгч шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулж тохиргоо хийх бөгөөд энэхүү гэрээнд заасан нөхцөлүүдээр үйлчилгээ үзүүлнэ.
- 2.2 Гэрээний 2.1-д заасан тоног төхөөрөмжүүд нь компаний өмч юм.
- 2.3 Үйлчлэгч техникийн үйлчилгээг төлбөртэй гүйцэтгэж болно.
- 2.4 Үйлчлэгч нь хэрэглэгчийн хүсэлтийн дагуу +18 контент хязгаарлах программ хангамжийн талаар зөвөлгөөг хүргэнэ.

3. Үйлчлэгчийн эрх, үүрэг

- 3.1 Үйлчлэгч нь дараах үүрэгтэй.
 - Хэрэглэгчийн сонгосон мэдээлэл дамжуулах үйлчилгээг ажлын 2-10 хоногт багтаан ашиглалтанд оруулна.
 - Хэрэглэгчийн сонгосон тухайн цэг хүртэл кабель татаж, сүлжээний тохиргоог хийнэ.
 - Гэрээ, түүний хавсралтанд өөрчлөлт оруулах тохиолдолд хэрэглэгчид энэ тухайгаа 2 хоногийн өмнөөс утсаар болон э-шуудангаар мэдэгдэнэ.
 - Хэрэглэгчийн үйлчилгээний хугацаа дуусахаас өмнө урьдчилан мэдэгдэнэ.
 - Үйлчилгээний төрөл, үнэ зэрэгт өөрчлөлт хийх тохиолдолд энэ тухайгаа хэрэглэгчид 1 сарын өмнө мэдэгдэнэ.
 - Зайлшгүй шалтгаанаар үйлчилгээ түр зогсоох шаардлага гарвал ажлын 1 хоногийн өмнө урьдчилан хэрэглэгчдэд мэдэгдэнэ.
 - Үйлчлэгчээс шалтгаалсан гэмтэл гарсан тохиолдолд хэрэглэгч 4.1 4-т зааснаар нэн даруй мэдэгдсэн тохиолдолд зөвхөн хугацааны нөхөн төлбөр олгоно.
 - Сүлжээ тасарсан дуудлага хүлээн авснаас хойш тухайн өдөртөө багтаан гэмтэл саатлыг шийдвэрлэх ба гадаад урсгал тасарсан, шилэн кабель тасарсан болон бусад үйлчлүүлэгчээс шалтгаалаагүй хүчин зүйлд ажлын 1-2 хоногт шийдвэрлэнэ.
 - Үйлчлэгч нь үйлчилгээний төлбөр хүлээн авсан сардаа багтаж хэрэглэгчийн ТТД дагуу и-баримтыг илгээнэ.
 - Үйлчлэгч нь хэрэглэгчийн сонгосон хурдыг "share"-лэхгүй, "dedicated" буюу хурдыг 100% олгоно.
- 3.2 Үйлчлэгч дараах эрхтэй.
 - Хэрэглэгчийн үйлчилгээний хугацаа дууссан үед үйлчилгээг түр хаах эрхтэй.
 - Үйлчилгээ эрхлэгч болон бусад сүлжээний аюулгүй байдал, хамгаалалт зэрэгт нөлөөлж болохуйц болон нөлөөлсөн сүлжээний халдлагын шинжтэй үйл ажиллагаа явуулсан үед үйлчилгээг түр хугацаагаар хязгаарлах, зогсоох, гэрээг цуцалж болно. Энэ тохиолдолд хэрэглэгчийн АЙПИ хаяг, MAC хаягийг хаана.
 - Хэрэглэгч энэхүү гэрээний нөхцөлийг зөрчвөл 3.3-т зааснаар шийдвэрлэх ба зөрчил арилтал үйлчилгээг хязгаарлах, түр хаах, гэрээг цуцлах эрхтэй.
 - **Үйлчлэгчид үл хамаарах техникийн гэмтэл, цахилгаан эрчим хүч тасрах буюу гэнэтийн үйлдлийн улмаас үүссэн үр дагаварын талаар хариуцлага хүлээхгүй.**
- 3.3 Үйлчлэгч дараах тохиолдолд үйлчилгээг цуцлах эрхтэй.
 - Дүр мэдэн сүлжээний тохиргоог өөрчилсөн тохиолдолд
 - Бүх төрлийн вирусын программ тараасан тохиолдолд
 - Сүлжээнд байгаа мэдээллийн зохиогчийн эрхийг зөрчсөн тохиолдолд
 - Бусад хэрэглэгчдийн мэдээллийн эх үүсвэрт зөвшөөрөлгүйгээр халдсан тохиолдолд

4. Хэрэглэгчийн эрх, үүрэг

- 4.1 Хэрэглэгч дараах үүрэгтэй.
 - Хэрэглэгч өөрийн мэдээллээ гэрээнд бүрэн гүйцэд, үнэн зөв бөглөнө.

- Үйлчилгээний зохих төлбөрийг цаг тухайд нь төлнө.
 - Хэрэглэгч үйлчилгээ авч буй байрлалаа сольсон тохиолдолд үйлчилгээ эрхлэгчид 3-с доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.
 - Гэрээний хавсралтанд тусгагдсан утас, оршин суугаа хаяг, э-шууданг өөрчлөгдсөн тохиолдолд шуурхай мэдэгдэнэ.
 - Үйлчилгээний талаарх гэмтэл, саатал гарсан тохиолдолд нэн даруй үйлчлэгчид мэдэгдэх бөгөөд хэрэв үл мэдэгдсэн болон хэрэглэгчээс шалтгаалсны улмаас интернэтээ ашиглаагүй тохиолдолд тэр хугацааны нөхөн төлбөр олгохгүй ба хэрэглэгч төлбөрөө бүрэн төлөх үүрэгтэй.
 - Хэрэглэгч нь хэрэглэгчийн нэр, нууц үгийг бусдад ашиглуулахгүйн үүднээс нууцлах үүрэгтэй ба хэрэв гуравдагч этгээд зөвшөөрөлгүйгээр ашигласан тохиолдолд түүнээс гарсан хариуцлагыг үйлчлэгч хүлээхгүй.
 - Үйлчилгээнд хамрагдахад шаардлагатай төхөөрөмжүүдийг бэлдсэн байх шаардлагатай.
 - Ижил төрлийн үйлчилгээг өөр үйлчилгээнээс авч үл болно.
 - Гэрээний 1.3-т хамрах хугацаанд үйлчилгээг цуцлах болон хурд бууруулах боломжгүй ба хэрэв үйлчилгээг цуцлах бол үлдсэн хугацааны төлбөрийн 50%-иу төлнө.
- 4.2 Хэрэглэгч дараах эрхтэй.
 - Зөвхөн хамрагдсан үйлчилгээний тарифын дагуу төлбөр хийх, үйлчилгээний талаар санал, гомдлоо илэрхийлэх.
 - Хэрэглэгч интернэтийн хурдаа ХХЗХ-с гаргасан www.speedtest.mn сайтыг ашиглан өөрийн үйлчилгээг хянаж боломжтой.
 - Хэрэглэгч өөрийн төлбөр тооцооны түүхийг үйлчилгээ эрхлэгчээс гаргуулан авах эрхтэй.
 - ХХЗХ-с зарласан нээлттэй интернэтийн портыг үргэлж нээлттэй ашиглах эрхтэй. Харин үйлчилгээ эрхлэгчээс санал болгосон болон бодит урсгалын интернэт үйлчилгээг авч буй тохиолдолд интернэтийн бүх порт нээлттэй байна.
 - Дотоодын вэб сайтруу 24 цагийн турш хурдны хязгааргүй ашиглана.
 - Нийтийн эзэмшлийн байр талбайд байрлах тоног төхөөрөмж, эд материалыг хэрэглэгч хариуцахгүй. Жишээлбэл: Үүнд байшингийн дээвэр, орц хонгил, лифт, 00 өрөөнд байрлах тоног төхөөрөмж багтана.
 - Төлбөр тооцоо, үйлчилгээнд өөрчлөлт оруулах ба бусад асуудлуудаар дараах утсаар холбоо барих эрхтэй 70113300 (ажлын өдрүүдэд 09:00-20:00, амралтын өдрүүдэд 10:00-18:00, ажлын бус цагаар дуут мессеж үлдээнэ үү).
 - www.billing.digicom.mn/radiusmanager/user.php вэб сайтаар ашигласан цагийг хянаж, хэрэглэгчийн нууц үгийг солих эрхтэй.
- ### 5. Төлбөр тооцоо
- 5.1 Интернэтийн холболт хийгдсэн өдрөөс хуанлийн 1 сараар асуудлуудаар дараах утсаар холбоо барих эрхтэй үр дүнд хуанлийн авна.
 - 5.2 Хэрэглэгчийн үйлчилгээний эрх нээгдсэн өдрөөр үйлчилгээ эхэлсэнд тооцно.
 - 5.3 Хэрэглэгч үйлчилгээ авч буй байрлалаа өөрчлөх болон хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас болж кабель тасалсан тохиолдолд холболтын хураамжийн 50% төлнө.
- ### 5.4 Хэрэглэгч нь сарын төлбөрөө тухайн сарынхаа холболт авсан өдрөөс өмнө хавсралтанд заасан үнийн дагуу УРЬДЧИЛАН төлнө.
- 5.5 Хэрэглэгч 5.1-т зааснаар төлбөр төлөгдөөгүй тохиолдолд үйлчилгээний эрх автоматаар хаагдана.
- ### 5.6 Төлбөр тооцоо хийгдээгүйн улмаас таслагдсан хугацааны төлбөрийг үйлчлэгч хариуцахгүй.
- 5.7 Хэрэглэгч төлбөрөө дараах аргуудаар төлнө:
 - Бэлнээр,
 - манай компаний www.digicom.mn сайтын баруун дээд буланд байх Нэвтрэх гэсэн хэсэгт гэрээний хавсралтын дагуу нэвтрэх нэр, нууц үгээ ашиглан нэвтрэх банкны картаар төлбөрөө төлсөн тохиолдолд үйлчилгээний эрх автоматаар нээгдэнэ.
 - ХХБанкны 499122544 тоот төгрөгийн, Голомт банкны 1105018970 тоот төгрөгийн, Хаан банкны 5111032747 тоот төгрөгийн дансанд төлнө.

6. Бусад зүйл

- 6.1 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн хохирлыг зохих хуулийн дагуу шийдвэрлэнэ.
- 6.2 Энэхүү гэрээний 3.3-т зааснаас бусад тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг цуцална.
- 6.3 Гэрээний явцад талуудын хооронд маргаан гарвал энэхүү гэрээг удирдлага болгон харилцан зөвшилцөх ба ХХЗХ-нд хандан шийдвэрлүүлнэ. Мөн талууд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг баримталж асуудлыг шийдвэрлэнэ.

Зөвшөөрсөн

Хэрэглэгчийн гарын үсэг

ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ/INTERNET SERVICE

Дугаар/Reference number:

Огноо/Date:

ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ/CUSTOMER INFORMATION

Хэрэглэгчийн нэр/Customer name: Регистрийн дугаар/ID Number:

Хаяг/Address:

Утас/Phone:

Гар утас/Mobile Phone:

Э-шуудан/E-mail:

Төлбөр хийх төрөл төрөл/Payment method:

Шилжүүлэг/ Wire Transfer

Карт/Card

Бэлэн/Cash

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ/SERVICE INFORMATION:

Үйлчилгээний төрөл/Service type:

GPON

FTTO

FTTB

Үйлчилгээний хурд/Service capacity:

25Mbps

50 Mbps

100Mbps

Сарын төлбөр/Monthly fee:

Холболтын хураамж/One time setup fee:

Эхэлсэн огноо/Service request date:

Гэрээний хугацаа/Contract terms:

24 сар

PPPoE	Хэрэглэгчийн нэр/Username:	
	Нууц үг/Password:	

Гарын _____
үсэг Дижиком ХХК

Гарын _____
үсэг Хэрэглэгч